



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/120

Мандалговь

Г Гэрээ байгуулах тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.1.1 дахь заалт, Засаг даргын тамгын газрын даргын 2017 оны А/97 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Цэнгэлдэх хүрээлэнгийн дотор, гадна тохижилтын ажил” /ДУАОНӨГ/201704033/-ын гүйцэтгэгчээр “Мандал шилтгээн” ХХК – ийг сонгон 45,081,300 /дөчин таван сая наян нэгэн мянга гурван зуун/ төгрөгөөр гүйцэтгүүлэхээр шууд гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг төсвийн дагуу ажлаа чанартай хийж гүйцэтгэхийг “Мандал шилтгээн” ХХК-ний захирал /Б.Ням/ -д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар /Э.Чагнаадорж/, Сайнцагаан сумын Засаг дарга /Р.Мөнхтогтох/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



О.ЧУЛУУНБАТ

0200348